
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

СУДАЛГААНЫ ТАЙЛАН



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

УДИРТГАЛ	3
НЭГ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО	5
1.1.Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох	17
1.2. Хүний нөөцийг тодорхойлох	31
1.3. Гарах зардлыг урьдчилан тооцох.....	83
1.4. Үр дүнг тооцох	84
1.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.	86
ДҮГНЭЛТ, САНАЛ	88
ХОЁР. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛ	90
2.1. Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн санхүүжилтийн нэгтгэл.....	90
2.2. Санхүүжилтийн бодолт, тооцоо.....	93
2.3. Эрүүл мэндийн салбарын төсөв ДНБ-д эзлэх хувь	94
2.4. Эрүүл мэндийн салбарын төсвийн үндсэн үзүүлэлт	96
2.5. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага	97
2.6. Эрүүл мэндийн даатгал — даатгуулагчийн төрлөөр.....	98
2.7. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын бүтэц	99
2.8. Монгол Улсын нэгдсэн төсвийн онцгой татварын орлого	99
2.9. Орон нутгийн төсвийн зарлага аймаг, нийслэлээр	100
НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ	102

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно” гэж заасан бөгөөд уг эрхийг бодитой хэрэгжүүлэхэд Эрүүл мэндийн тухай хууль нь голлох органик хууль юм. 2011 онд батлагдсан Эрүүл мэндийн тухай хууль нь батлагдаад өнөөдрийн байдлаар 15 дахь жилдээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ба шинэчлэх хэрэгцээ, шаардлага бий болсноор тухайн Эрүүл мэндийн тухай хуулийн төслийг боловсруулсан.

2024 онд батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл”-ийн 1.18 дахь хэсгийн 143-д тусгасан ба Эрүүл мэндийн тухай хуулийн төслийг шинэчлэн найруулж батлахаар төлөвлөсөн.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 2.2.11-д “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна.” гэж, 2.2.12-т “Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламжийн ачааллыг тэнцүүлж хүн амд чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй “Үйлчлүүлэгч төвтэй” тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавх бүхий эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжинэ.” гэж тус тус заасныг хэрэгжүүлэх хүрээнд энэхүү төслийг боловсруулсан байна.

Мөн Эрүүл мэндийн тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, эрүүл мэндийн байгууллагын засаглалын бие даасан байдал, удирдах албан тушаалд томилогдох шалгуурыг Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн нарийвчлан тусгах, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар түүний харьяа эрүүл мэндийн байгууллага нь салбарын бодлогын хэрэгжилт болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмж, үр дүнг харьяалах дээд шатны байгууллагын өмнө бүрэн хариуцдаг байх, эмнэлгийн тусламж, үйлчилгээний шатлалыг тусламж үйлчилгээнд тавигдах шаардлага, санхүүжилтийн үр ашигтай байдалд уядуулан тогтоох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагын төрөл, чиг үүргийг тусламж, үйлчилгээний чиглэлтэй нь нийцүүлэн оновчтой тодорхойлох хэрэгцээ, шаардлага үүссэн.

Тодруулбал, эрүүл мэндийн салбарын эрх зүйн зохицуулалт нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах үндсэн зорилготой хэдий ч өнөөгийн нөхцөлд зарим зохицуулалт нь салбарын хөгжлийн шаардлагатай бүрэн нийцэхгүй, давхардал болон хийдэл бүхий байдал ажиглагдаж байна. Ялангуяа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний удирдлага, санхүүжилт, хүний нөөцийн бодлого, хариуцлагын тогтолцоо зэрэг асуудлыг цогцоор нь уялдуулан шинэчлэх шаардлага бодитоор тулгарч байна. Мөн хүн амын насжилт, халдварт болон халдварт бус өвчний бүтэц өөрчлөгдөх, эрүүл мэндийн технологи, дижитал шилжилт эрчимжих зэрэг хүчин зүйлс нь салбарын эрх зүйн орчныг шинэ түвшинд авч үзэх хэрэгцээг бий болгож байна.

Түүнчлэн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, аюулгүй байдал, иргэдийн тэгш хүртээмжтэй үйлчилгээ авах эрхийн хэрэгжилт хангалтгүй байгаатай холбоотойгоор эрх зүйн тодорхой зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага үүсэж байна. Эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийн үр ашиг, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо сул байгаагаас үйлчилгээний үр дүн, хариуцлагын механизм хангалттай түвшинд хүрээгүй байна. Мөн эрүүл мэндийн даатгалын тогтолцооны уялдаа, төр-

хувийн хэвшлийн түншлэл, анхан шатны тусламж үйлчилгээний бэхжилт зэрэг асуудлыг нэг мөр, цогц байдлаар зохицуулах хэрэгцээ нэмэгдэж байна.

Дээрх хууль зүйн болон практик шаардлагыг үндэслэн эрүүл мэндийн салбарын эрх зүйн орчныг шинэчлэх, уялдаа холбоог сайжруулах, давхардал, хийдлийг арилгах зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан болно.

Хууль тогтоомжийн тухай хууль¹-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасан. Үүний дагуу, Эрүүл мэндийн тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх болон нэмэгдэх үүргийн улмаас бий болох зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан тооцож, судалгаа хийх шаардлага үүссэн байна.

Судалгааны зорилго. Эрүүл мэндийн тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, хялбарчлах болон бууруулах боломжит хувилбар бүхий санал боловсруулах, зардал, үр өгөөжийн харьцааг үнэлэхэд энэхүү судалгааны зорилго чиглэгдэнэ.

Тус хуулийн төсөлд иргэнд шинээр болон нэмэлт зардал үүсгээгүй байх тул энэхүү зардлын тооцооны судалгааг дараах үндсэн бүтцийн дагуу гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төрийн байгууллагын зардлын тооцоо;
2. Хуулийн этгээдийн зардлын тооцоо;

Ингэхдээ Эрүүл мэндийн тухай хуулийн төсөлтэй холбоотой зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцоолсон ба анхдагч хуулийн төсөл учраас хуулийн төсөлд тусгагдсан зардал гарах бүх хэм хэмжээг сонгон авсан болно.

Судалгааны үр дүнд үндэслэн, тус хуулийн төсөл батлагдсанаар үүсэх зардлыг тооцон, зардал ба үр өгөөжийн харьцааг дүгнэж тайлан боловсруулав.

¹ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан, <https://legalinfo.mn/mn/detail/11119>

НЭГ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцох бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- Байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
- Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
- Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

Төрийн байгууллагын бүтэц бүрэлдэхүүн, зардал, ажлын ачаалалд нөлөө үзүүлэх боломжтой зохицуулалтыг сонгож авахдаа Эрүүл мэндийн тухай хуулийн төсөл нь шинэ харилцааг зохицуулж буй анхдагч хуулийн төсөл гэж ойлгож болох ч зарим чиг үүргийг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар зохицуулж болохоор байна. Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд тусгасан чиг үүргүүдээс нэмэлтээр буюу шинээр чиг үүргүүдийг Эрүүл мэндийн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгад тусгасан байна. Иймд тухайн зардлын тооцоог энэ шинэ чиг үүргүүдийн хүрээнд хийлээ.

Эрүүл мэндийн тухай хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгт хамаарах /Хүснэгт.1-д заасан/ дараах заалтууд байна. Үүнд:

Хүснэгт 1. Зардалд нөлөөлөх зүйл заалт

Хуулийн төслийн төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл заалт
<p>12.1.Монгол Улсын Их Хурал эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>12.1.3.онцгой нөхцөл байдал, гамшиг, тахлын үед хүн амын эрүүл мэнд, амь насыг хамгаалахтай холбогдох эрх зүйн зохицуулалтыг шуурхай батлах;</p>	<p>12.1.1.төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг тодорхойлох;</p> <p>12.1.2.эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд парламентын хяналт</p> <p>12.1.4.эрүүл мэндийн асуудлаар олон улсын гэрээнд нэгдэх, соёрхон батлах, цуцлах асуудлыг шийдвэрлэх;</p> <p>12.1.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p>
<p>13.1.Монгол Улсын Засгийн газар /цаашид "Засгийн газар" гэх/ эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>13.1.5.зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэнд санхүүжилт олгох журмыг батлах;</p>	<p>13.1.1.төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах;</p> <p>13.1.2.эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;</p> <p>13.1.3.эрүүл мэндийн талаар батлагдсан бодлого, хөтөлбөрийг санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>13.1.4.эрүүл мэндийн салбар дахь хамтын ажиллагааны асуудлаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд бусад улсын Засгийн газар, олон улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр хийх;</p>
<p>14.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>14.1.4.эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлэх, давтан сургах бодлогыг тодорхойлж,</p>	<p>14.1.1.эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;</p> <p>14.1.2.хүн амын эрүүл мэндийн байдлыг судлах, хянах, үнэлэх, эрэлт хэрэгцээг</p>

<p>хэрэгжилтийг хангуулах, эрүүл мэндийн мэргэжлийн чиглэл, индекс, анагаах ухааны боловсролын сургалтын байгууллагын элсэлтийн хяналтын тоо, сургалтын түшиц эмнэлгээр хангах асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэх;</p> <p>14.1.9.эрүүл мэндийн статистик мэдээллийг нэгтгэн гаргах, мэдээлэх;</p> <p>14.1.11.эрүүл мэндийн салбарын хөгжил, эрүүл мэндийн ажилтны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах, судалгаа хийх;</p> <p>14.1.16.эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг захиалан гүйцэтгүүлэх.</p>	<p>үндэслэн эрүүл мэндийн салбарын бодлого, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох;</p> <p>14.1.3.хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар иргэд, төрийн болон төрийн бус байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;</p> <p>14.1.5.аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хянах;</p> <p>14.1.6.эрүүл мэндийн удирдлага, мэдээллийн тогтолцооны бодлогыг тодорхойлох, мэдээллээр хангах;</p> <p>14.1.8.магадалгааны нэгдсэн сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авах, хэвийн, найдвартай үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах;</p> <p>14.1.10.төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, нэгдсэн болон тусгай эмнэлэг, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын харьяанд ажилладаг бусад төрийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;</p> <p>14.1.12.иргэний эрүүл мэндээ хамгаалах, өвчлөхөөс урьдчилан сэргийлэх, өвчин, эмгэг, гэмтлийн улмаас эрүүл мэндэд үүсэх үр дагаврыг багасгах, арилгах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх, эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах;</p> <p>14.1.13.эрүүл мэндийн ажилтныг төгсөлтийн дараах сургалтад хамруулах, мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг зохион байгуулах;</p> <p>14.1.14.эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах;</p> <p>14.1.15.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох үйл ажиллагааг зохион байгуулах;</p>
<p>15.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>15.1.2.эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх;</p> <p>15.1.3.эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх;</p> <p>15.1.6.хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг салбарын хэмжээнд төлөвлөх, зохион байгуулах, эрүүл мэндийн байгууллагын байршил, бүтэц, зохион байгуулалт, тусламж, үйлчилгээний төрөл, шатлал, эмнэлгийн болон сувиллын орны дээд хязгаарыг тогтоох;</p> <p>15.1.9.хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс</p>	<p>15.1.1.хүн амын эрүүл мэндийг хамгаалах, бэхжүүлэх үндэсний хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцох;</p> <p>15.1.4.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн бодлогыг тодорхойлох, төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>15.1.5.эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн бодлогыг холбогдох байгууллагатай хамтран тодорхойлох;</p> <p>15.1.7.эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн бодлогыг холбогдох байгууллагатай хамтран тодорхойлох;</p> <p>15.1.8.эрүүл мэндийн салбарт Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд зааснаар төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг төлөвлөх, төслийн санал гаргах, төр, хувийн</p>

<p>урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>15.1.10. аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, эмнэлгийн даргад тавигдах мэргэжлийн шаардлагыг тогтоох;</p> <p>15.1.11.аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын даргыг энэ хуулиар тогтоосон шаардлага болон Төрийн албаны тухай хуульд заасан сонгон шалгаруулалтын шалгалтын дүнг үндэслэн томилж, хуульд заасны дагуу чөлөөлөх;</p> <p>15.1.12.эрүүл мэндийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын бүтэц, орон тоог тухайн нутаг дэвсгэр дэх хүн амын тоо, төвөөс алслагдсан байдлыг үндэслэн батлах;</p> <p>15.1.14.төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг улсын болон бүсийн хэмжээнд бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангах үйл ажиллагааг зохицуулах журам, тусламж, үйлчилгээний чиглэл, хамрах хүрээг батлах;</p> <p>15.3.Энэ хуулийн 15.2-т заасан мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>15.4.Эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээг боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээтэй хослуулан үзүүлэх журам, жагсаалтыг эрүүл мэндийн, боловсролын болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.</p>	<p>хэвшлийн түншлэлийн гэрээний хэрэгжилтийг хангах, хяналт тавих;</p> <p>15.1.13.эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцыг батлах;</p> <p>15.1.15.хүний амь насанд аюултай, хөгжлийн бэрхшээлд хүргэдэг ховор тохиолдох өвчин, эмгэгийг тодорхойлох аргачлалыг батлах;</p> <p>15.1.16. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p> <p>15.2.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд эрүүл мэндийн салбарын бодлого, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулахад нь зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл байгуулан ажиллуулж болно.</p>
<p>16.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>16.1.5.орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх жил бүрийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, арга хэмжээний төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийн тайланг хүлээж авч дүгнэлт өгөх;</p>	<p>16.1.1.эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;</p> <p>16.1.2.харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн асуудлаар Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэн дүгнэлт өгөх;</p> <p>16.1.3.харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар хөтөлбөр, шийдвэр гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>16.1.4.харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, иргэний хамтын оролцоог хангаж, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах;</p>
<p>20 дугаар зүйл.Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл</p> <p>20.1.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг салбар хоорондын хамтын ажиллагаа, оролцоонд тулгуурлан хангах зорилгоор Ерөнхий сайдын дэргэд орон тооны бус Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ ажиллана.</p>	

20.2.Зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

20.2.1.нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тулгамдсан асуудлыг хэлэлцэж, баримтлах бодлогыг тодорхойлох;

20.2.2.холбогдох яам, агентлаг болон бусад байгууллагын нийгмийн эрүүл мэндтэй хамааралтай үйл ажиллагааны уялдааг хангах;

20.2.3.нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого, хөтөлбөрт салбар дундын байр суурь, саналыг тусгах;

20.2.4.Засгийн газрын богино болон дунд хугацааны хөтөлбөр, арга хэмжээнд тусгагдсан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зорилтот шалгуур үзүүлэлтийн биелэлтэд хяналт тавих, үнэлгээ өгөх.

20.3.Зөвлөлийн дарга нь Ерөнхий сайд байх бөгөөд орлогч дарга нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, нарийн бичгийн дарга нь нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга байна. Зөвлөлийн гишүүд нь дараах төлөөллөөс бүрдэнэ:

20.3.1.эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчин, санхүү, хууль зүй, онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд;

20.3.2.нийслэлийн засаг дарга;

20.3.3.хангайн, баруун, хойд, төвийн, зүүн, говийн бүс тус бүрээс нэг аймгийн засаг дарга.

20.4.Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдаанаас гарсан тогтоолын хэрэгжилтийг Засгийн газрын гишүүд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар өөрийн бүрэн эрхийн хүрээнд хариуцна.

20.5.Зөвлөл нь цахимаар эсхүл танхимаар жилд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хуралдааны товыг мэдэгдэх, хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг гаргах зэрэг шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг хариуцна.

20.7.Зөвлөлийн хуралдааныг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн даргалах бөгөөд хуралдааны дэгийг хуралдаанд оролцогчдын олонхын саналаар тогтооно.

20.8.Хуралдаанаар аймаг, нийслэлийн Засаг дарга нар тухайн бүс нутгийн нийгмийн эрүүл мэндийн төвшний талаар танилцуулга хийх бөгөөд хуралдаанд ашигласан танилцуулга

<p>болон холбогдох бусад мэдээллийг олон нийтэд ил тод тайлагнана.</p>	
<p>21 дүгээр зүйл.Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага</p> <p>21.1.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлогын хэрэгжилт, зохион байгуулалтыг нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.</p> <p>21.2.Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга нь Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан Улсын онцгой комиссын гишүүн болон эрүүл мэндийн дэд сайдын чиг үүргийг хавсран гүйцэтгэнэ.</p> <p>21.3.Орон нутгийн хүн амд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлогын хэрэгжилт, зохион байгуулалтыг аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллагаар дамжуулан хангуулна.</p> <p>21.4.Хүн амыг олноор хамарсан халдварт өвчний дэгдэлт болон аюулт үзэгдлийн үед голомтыг хязгаарлах, цомхотгох, хохирлыг багасгахад чиглэсэн эрүүл мэндийн байгууллагын дангаар болон төр, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтран үзүүлэх гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу байгуулагдсан гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба мөн хуульд заасны дагуу зохион байгуулна.</p> <p>21.5.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, чиглэл, тэдгээрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбогдох бусад харилцааг Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай болон бусад холбогдох хуулиар зохицуулна.</p>	
<p>22 дугаар зүйл.Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх</p> <p>22.1.Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дараах бүрэн эрхтэй:</p> <p>22.1.1.нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үндэсний бодлогод нийцүүлсэн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнд үнэлгээ өгөх;</p>	

<p>22.1.2.халдварт болон халдварт бус өвчний тандалт, хяналтын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх, олон нийтийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй нөхцөл байдалд хариу арга хэмжээ авах;</p> <p>22.1.3.дархлаажуулалт, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх арга хэмжээ боловсруулах, хэрэгжүүлэх;</p> <p>22.1.4.нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын стандарт тогтоох, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих;</p> <p>22.1.5.нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, судалгааны нэгдсэн тогтолцоог хөтлөх, эрдэм шинжилгээ, судалгааг дэмжих, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байдлын үндэсний илтгэлийг жил бүр гаргах;</p> <p>22.1.6.хүрээлэн буй орчин, хүнс, усны эрүүл ахуйн шаардлагын биелэлтэд хяналт тавих, зөрчил гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох;</p> <p>22.1.7.олон улсын эрүүл мэндийн байгууллагын дүрэм, журмын үүргийг хэрэгжүүлэх, Засгийн газрын гэрээ, хэлэлцээрийн дагуу нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр хамтран ажиллах.</p>	
<p>24 дүгээр зүйл.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага</p> <p>24.1.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний бодлогын хэрэгжилт, зохион байгуулалт, зохицуулалтыг эмнэлгийн тусламж, үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.</p> <p>24.2.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний шаталсан тогтолцооны үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, анхан, хоёрдогч, гуравдагч шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээний уялдаа холбоог хангана.</p> <p>24.3.Орон нутгийн хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний бодлогын хэрэгжилт, зохион байгуулалтыг аймаг, нийслэл, дүүргийн эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан хангуулна.</p> <p>24.4.Хүн амыг олноор хамарсан халдварт өвчний дэгдэлт, гамшиг, онцгой нөхцөл байдлын үед эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, шаардлагатай эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлнэ.</p>	

<p>24.5.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төрөл, чиглэл, тэдгээрийн удирдлага, зохион байгуулалт болон эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбогдох бусад харилцааг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай болон бусад холбогдох хуулиар зохицуулна.</p>	
<p>25 дугаар зүйл. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх</p> <p>25.1.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>25.1.1.хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, шаардлагад үндэслэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний сүлжээ, хүчин чадал, үйлчилгээний төрөл, хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох судалгааг 3 жил тутам гаргах;</p> <p>25.1.2.эмнэлгийн тусламж, үйлчилгээний шаталсан тогтолцооны зохион байгуулалт, төлөвлөлтийг хэрэгжүүлэх;</p> <p>25.1.4.эрүүл мэндийн технологийн үнэлгээг зохион байгуулах, хэрэгжүүлэх;</p> <p>25.1.5.эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад олгох тусгай зөвшөөрлийг 25.1.1-д заасан хэрэгцээ, шаардлагын судалгаанд үндэслэн шийдвэрлэхэд мэргэжлийн дүгнэлт гаргах;</p> <p>25.1.6.эмнэлгийн байгууллагаас бүрдүүлэх мэдээллийг нэгтгэн боловсруулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;</p> <p>25.1.7. эрүүл мэндийн байгууллагын эрүүл мэндийн технологийн үнэлгээ хийх нэгжийг мэргэжил, арга зүйгээр хангах;</p> <p>25.1.8.иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэх.</p>	
<p>29.7.Эрүүл мэндийн санхүүжилтийн эх үүсвэр бүрийг нэгдсэн мэдээллийн санд бүртгэх, хянах, тайлагнах тогтолцоог эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж, хэрэгжилтийг хангана.</p>	<p>29.1.Эрүүл мэндийн салбарын нийт санхүүжилтийн хэмжээ тухайн жилийн Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 5-аас доошгүй хувь байна.</p> <p>Тайлбар: - “Эрүүл мэндийн салбарын нийт санхүүжилтийн хэмжээ” гэдэгт Төсвийн тухай хуульд заасан Эрүүл мэндийн сайдын багцад хамаарах зардал болон харьяа байгууллагад олгосон санхүүжилтийн нийт хэмжээг ойлгоно. /Энэ заалтыг 2028 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./</p> <p>29.2.Эрүүл мэндийн салбарын нийт санхүүжилтэд хамаарах бүрэлдэхүүн хэсгийн санхүүжилтийн хувь, хэмжээг дараах байдлаар тооцно:</p> <p>29.2.1.даатгуулагч, ажил олгогч хамтран сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг түүний хөдөлмөрийн</p>

хөлс, түүнтэй адилтгах орлогын 4-өөс доошгүй хувиар сар бүр;

29.2.2.иргэн өөрөө бүрэн хариуцан төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 4-өөс доошгүй хувиар сар бүр;

29.2.3.эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь улсын төсвөөс хариуцан төлөх иргэдийн жагсаалтыг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар тодорхойлох бөгөөд тухайн иргэний төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 6-аас доошгүй хувиар сар бүр;

29.2.4.анхан шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн хэмжээг тооцохдоо тухайн жил Монгол Улсад оршин суугаа нийт хүн амын тоог нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 4-өөс доошгүй хувиар үржүүлж, сар бүр;

29.2.5.эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийн хэмжээг тооцохдоо чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, бүх төрлийн согтууруулах ундаа, бүх төрлийн тамхины онцгой албан татвар болон эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 20 хувиар жил бүр;

29.2.6.нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг орон нутагт хангахад шаардлагатай санхүүжилтийн хэмжээг тооцохдоо тухайн жилийн орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн 5-аас доошгүй хувиар жил бүр;

29.2.7.эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт болон бодлого, удирдлага, нийгмийн эрүүл мэндийн тогтолцооны зардлыг Төсвийн тухай хуульд заасны дагуу жил бүр.

29.3. Засгийн газар нь энэ хуулийн 29.2.1-29.2.4-т заасныг баримтлан Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, татварын болон эрүүл мэндийн салбарын тэргүүлэх чиглэл, салбарын нийт санхүүжилтийн хэмжээтэй уялдуулан санхүүжилтийн хувь, хэмжээг жил бүрийн 12 сард багтааж тогтооно.

29.4.Энэ хуулийн 29.3-т заасан хувь, хэмжээ нь тухайн жилийн Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 5-аас доошгүй хувийг эзлэхгүй тохиолдолд энэ хуулийн 29.1-т заасан эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

29.5.Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь энэ хуулийн 29.2.6-т заасан төсвийг зарцуулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулан хэрэгжилтийг хангана.

	29.6.Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам, жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төлбөрийн жишиг хэмжээг санхүүгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.
30 дугаар зүйл.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн зохицуулалт	
31 дугаар зүйл.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн зохицуулалт	
32 дугаар зүйл.Эм зүйн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн зохицуулалт	
31.8.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний шатлал хооронд өвчтөн илгээх, эргэн мэдээлэх, хянах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	
33.3.Судалгаа, эрдэм шинжилгээний санхүүжилтийг олгох, зарцуулах, үр дүнг үнэлэх журмыг эрүүл мэндийн болон шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	
34.2.Эрүүл мэндийн санхүүжилтийн үр ашгийг санхүүжилтийн зардал болон хүн амын эрүүл мэндийн байдалд гарсан үр дүнгийн үзүүлэлтээр хэмжих бөгөөд эрүүл мэндийн байгууллага, орон нутаг, үндэсний түвшинд үнэлнэ.	
38.3.Эрүүл мэндийн санхүүжилттэй холбоотой мэдээллийг нэгдсэн цахим тогтолцоогоор нийтэд нээлттэй байлгах бөгөөд санхүүжилтийн зарцуулалтын талаарх иргэний гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариуцлага тооцох журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	
39.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь улсын хэмжээнд эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийг зохистой байлгах нэгдсэн төлөвлөгөөг 4 жилээр боловсруулж, хэрэгжүүлнэ.	
39.3.Энэ хуулийн 39.2-т заасан нэгдсэн төлөвлөгөөг аймаг, нийслэлд хэрэгжүүлэх төлөвлөгөөг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн нутгийн өөрөө удирдах байгууллагатай жил бүр хамтран баталж, хэрэгжүүлнэ.	

<p>39.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан энэ хуулийн 39.3-т заасан төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнана.</p>	
<p>39.5.Энэ хуулийн 39.4-т заасан тайланг хүлээн авсан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь хэрэгжилтийг үнэлж, дүгнэлт гаргах бөгөөд дүгнэлтээ эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.</p>	
<p>39.6.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь 4 жил тутам эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийн талаар дараах судалгааг гүйцэтгэж, байгууллагын цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд мэдээлнэ:</p>	<p>39.6.1.эрүүл мэндийн ажилтныг бэлтгэх болон хөдөлмөрийн зах зээлд нийлүүлж буй байдал; 39.6.2.зөвшөөрөлтэй эрүүл мэндийн ажилтны тоо, бүртгэл, мэргэшүүлэх болон давтан сургалтад хамрагдсан байдал; 39.6.3.аймаг, нийслэл, сум, дүүрэг болон эрүүл мэндийн байгууллага тус бүрийн эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийн нөхцөл байдал; 39.6.4.эрүүл мэндийн үйлчилгээ дутмаг эсхүл хэт ачаалалтай нутаг дэвсгэр дэх эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийн хуваарилалтын нөхцөл байдал; 39.6.5.эрүүл мэндийн ажилтны ажлын нөхцөл, цалин хөлс, ачаалал, нийгмийн баталгааны хэрэгжилт, ажлаас чөлөөлөгдөх эсхүл шилжиж буй шалтгаан, ажилтны сэтгэл ханамж зэрэг хөдөлмөрийн нөхцөл байдлын шинжилгээ; 39.6.6.шаардлагатай гэж үзсэн бусад судалгаа.</p>
<p>42.1.Дижитал эрүүл мэндийг дэмжих хүрээнд дижитал эрүүл мэндийн үндэсний тогтолцоог хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл үүсгэх, олон улсын сайн туршлагыг судлан, улсын хэмжээнд дижитал эрүүл мэндийг тасралтгүй хөгжүүлэх, нэвтрүүлэх чиглэл, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг улсын хөгжлийн 5 жилийн чиглэлтэй уялдуулан Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.</p>	
<p>42.2.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь энэ хуулийн 42.1-д заасан жилийн төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэлийн тайланг дараа жилийн 1 дүгээр сард багтаан олон нийтэд нээлттэй эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулна.</p>	
<p>43.2.Дижитал эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамж зэрэг мэдээллийн технологийн бүтээгдэхүүн бүрд шавигдах шаардлагыг тогтоох, үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журмыг Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын</p>	<p>43.1.Дижитал эрүүл мэндийн үндэсний тогтолцоог бүрдүүлэхэд Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн олон улсын сайн туршлагын дагуу хөгжүүлсэн, орчин үеийн технологид суурилсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, бүтээгдэхүүнийг нэн тэргүүнд дэмжих бодлогыг баримтална.</p>

<p>гишүүн, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.</p>	<p>43.4.Эрүүл мэндийн байгууллага нь хуулийн этгээд, хувь хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд энэ хуулийн 43.3-т заасан жагсаалтад багтсан дижитал эрүүл мэндийн үйлчилгээ, бүтээгдэхүүнийг ашиглах үүрэгтэй.</p>
<p>43.3.Техникийн шаардлага хангасан дижитал эрүүл мэндийн үйлчилгээ, бүтээгдэхүүний жагсаалтыг хөгжүүлсэн хуулийн этгээдийн мэдээллийн хамт олон нийтэд нээлттэй эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулна.</p>	
<p>43.5.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нь хуулийн этгээдийн хөгжүүлсэн дижитал эрүүл мэндийн үйлчилгээ, бүтээгдэхүүнийг энэ хуулийн 43.2-т заасан техникийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт гаргаж, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулан батлуулна.</p>	
<p>44.1.Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан нь төрөлжсөн мэдээллийн санд хамаарах бөгөөд эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааг сайжруулах, эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг баталгаажуулах, өвчтөний эрхийг хангах, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой мэдээллийг боловсруулахад ашиглагдана.</p>	
<p>44.3.Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж Засгийн газар батална.</p>	
<p>46.1.Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн эрүүл мэндийн мэдээлэлд үндэслэн тухайн жилийн хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтийн статистикийн мэдээллийг гаргаж, олон нийтэд нээлттэй эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулна.</p>	<p>46.3.Эрүүл мэндийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийж гүйцэтгэх, эрүүл мэндийн статистик мэдээллийг цуглуулах, эрүүл мэндийн бодлого тодорхойлох зорилгоор эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон түүний харьяа байгууллагын албан хаагчид мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгосон дараах мэдээлэлтэй танилцах эрхтэй:</p>
<p>46.2.Эрүүл мэндийн үзүүлэлтийн статистикийн мэдээллийг гаргахтай холбоотойгоор Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэх мэдээллийн ангилал, жагсаалтыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>46.3.1.өвчтөний талаарх мэдээлэл; 46.3.2.үйлчилгээ үзүүлэгчийн мэдээлэл; 46.3.3.хэвтэн эмчлүүлэх үйлчилгээний мэдээлэл; 46.3.4.амбулаторийн болон өдрийн эмчилгээний мэдээлэл; 46.3.5.оношны мэдээлэл; 46.3.6.эмийн мэдээлэл;</p>

	<p>46.3.7.өвчтөний эрүүл мэндийн байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд; 46.3.8.хийсэн мэс ажилбар, шинжилгээ, эмчилгээний үйл явц. 46.4.Энэ хуулийн 46.3-т заасан мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгосон мэдээллийг таньж тодорхойлох боломжтой болгохыг хориглоно.</p>
<p>52.2.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь шаардлагатай тохиолдолд хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх асуудлаар бусад салбарын төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах, санал хүргүүлэх, хамтарсан арга хэмжээ, хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулна.</p>	<p>52.1.Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийг бууруулах үйл ажиллагааг салбар дундын хамтын ажиллагааны үндсэн дээр хэрэгжүүлнэ.</p>
<p>52.3.Бусад төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тавьсан санал, зөвлөмжийг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан үзэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах, шаардлагатай мэдээллээр хангах, хамтарсан арга хэмжээнд оролцох үүрэгтэй.</p>	
<p>52.4.Энэ хуулийн холбогдох хэсэгт заасан төрийн байгууллага нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хүсэлтээр шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгаа, тайлан, тоон мэдээлэл, лавлагааг тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй.</p>	
<p>52.5.Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр хамтран хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөв, санхүүжилтийн асуудлыг холбогдох төрийн байгууллага хамтран төлөвлөж, шийдвэрлэнэ.</p>	
<p>52.6.Энэ хуулийн 52.5-д заасан арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай төсвийг тухайн салбарын Засгийн газрын гишүүн эсхүл Төсвийн тухай хуульд заасан бусад төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсөвт тусгаж батлуулна.</p>	
<p>14⁵.1.Эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, өвчтөний аюулгүй байдлын талаар хяналт тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлнэ. 14⁵.2.Дотоод хяналт хариуцсан алба(эсхүл ажилтан) нь байгууллагын удирдлагад шууд тайлагнах бөгөөд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ: 14⁵.2.1.чанар, аюулгүй байдалтай холбоотой шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг хуульд нийцүүлэн гаргуулан авах;</p>	

<p>14⁵.2.2.дотоод аудит, эрсдэлийн үнэлгээ хийх, зөрчил, дутагдлыг бүртгэх, шинжлэх;</p> <p>14⁵.2.3.зөрчил, дутагдлыг арилгах болон давтан гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулах, хэрэгжилтийг хянах, хаалтын нотолгоог бүрдүүлэх;</p> <p>14⁵.2.4.ажилтны сургалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах.</p> <p>14⁵.3.Дотоод хяналтаар илэрсэн зөрчил, дутагдлыг эрүүл мэндийн байгууллага нь тухай бүр арилгаж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж хэрэгжүүлнэ.</p> <p>14⁵.4.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд дотоод хяналт тавих албаны үлгэрчилсэн дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>14⁵.5.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд эрүүл мэндийн чанарын хяналтын орон тооны бус зөвлөл ажиллуулж болох бөгөөд зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	
---	--

1.1.Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын чиг үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;
2. Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. Чиг үүрэгт хэрэгжүүлэх, хэмжих боломжтой агуулгыг хамааруулах.

Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Иймд Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хүрээнд төрийн байгууллагаас хэрэгжүүлэх бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоонд хамааруулан тооцдоггүй бөгөөд стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо ерөнхий байдлаар бүлэглэн тодорхойлов.

Мөн түүнчлэн өмнөх чиг үүрэгтэй холбоотой зохицуулалтуудаас тохиолдлын тоог нь тогтоох боломжгүй үйл ажиллагаа буюу хуулийн хэрэгжилтэд хяналт тавих түүнчлэн төрийн захиргааны төв байгууллагын бодлого боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцоонд оруулж тооцоогүй болно.

Хүснэгт 2. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь

Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа
Монгол Улсын Их Хурал	12.1.3. онцгой нөхцөл байдал, гамшиг, тахлын үед хүн амын эрүүл мэнд, амь насыг хамгаалахтай холбогдох эрх зүйн зохицуулалтыг шуурхай батлах	<ul style="list-style-type: none"> - Онцгой нөхцөл байдал, гамшиг, тахлын үеийн эрсдэл, нөхцөл байдлыг үнэлэх - Хүн амын эрүүл мэнд, амь насыг хамгаалахад шаардлагатай эрх зүйн зохицуулалтын хэрэгцээг тодорхойлох - Шуурхай хэрэгжүүлэх хууль, журам, шийдвэрийн төслийг боловсруулах - Эрх бүхий байгууллагаар хэлэлцүүлэн шуурхай батлах - Батлагдсан зохицуулалтыг хэрэгжүүлэх, олон нийтэд мэдээлэх - Хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулах
Засгийн Газар	13.1.5. зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэнд санхүүжилт олгох журмыг батлах	<ul style="list-style-type: none"> - Гадаад улсад эмчлүүлэх зайлшгүй шаардлагыг тодорхойлох шалгуур боловсруулах - Санхүүжилт олгох нөхцөл, хэмжээ, эх үүсвэрийг тогтоох - Иргэний хүсэлт, холбогдох баримт бичгийг хянан шийдвэрлэх журам боловсруулах - Санхүүжилт олгох, зарцуулалтад хяналт тавих журмыг батлах - Батлагдсан журмын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих
	44.3. Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж Засгийн газар батлана.	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалахтай холбоотой шаардлага, стандартын хэрэгцээг тодорхойлох - Эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зохицуулалтын төсөл боловсруулах - Эрүүл мэнд болон цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран журмын төслийг боловсруулах - Холбогдох байгууллагуудаас санал авч, уялдаа хангах - Журмын төслийг Засгийн газарт өргөн мэдүүлж батлуулах

<p>Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага</p>	<p>14.1.4. эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлэх, давтан сургах бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг хангуулах, эрүүл мэндийн мэргэжлийн чиглэл, индекс, анагаах ухааны боловсролын сургалтын байгууллагын элсэлтийн хяналтын тоо, сургалтын түшиц эмнэлгээр хангах асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлэх, давтан сургах бодлого, хэрэгцээг тодорхойлох - Мэргэшүүлэх, давтан сургах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, хангуулах - Эрүүл мэндийн мэргэжлийн чиглэл, индекс, элсэлтийн хяналтын тоог боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэх - Анагаах ухааны сургалтын байгууллагыг сургалтын түшиц эмнэлгээр хангах асуудлыг зохион байгуулах
	<p>14.1.9. эрүүл мэндийн статистик мэдээллийг нэгтгэн гаргах, мэдээлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн статистик мэдээллийг цуглуулах - Статистик мэдээллийг нэгтгэн боловсруулах - Нэгдсэн статистик мэдээллийг мэдээлэх, тайлагнах - Мэдээллийн үнэн зөв, бүрэн байдалд хяналт тавих
	<p>14.1.11. эрүүл мэндийн салбарын хөгжил, эрүүл мэндийн ажилтны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах, судалгаа хийх</p>	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн салбар болон эрүүл мэндийн ажилтны хөгжлийн бодлого боловсруулах, чиглэлийг тодорхойлох - Бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, хангуулах - Эрүүл мэндийн салбарын хөгжил, хүний нөөцтэй холбоотой судалгаа хийх - Судалгааны үр дүнд үндэслэн бодлогын хэрэгжилтийг үнэлэх, сайжруулах
	<p>14.1.16. эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг захиалан гүйцэтгүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудлыг тодорхойлох - Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чиглэл, захиалгыг боловсруулах - Судалгааны ажлыг сонгон шалгаруулж, захиалан гүйцэтгүүлэх - Судалгааны үр дүнг хүлээн авах, ашиглах, хэрэгжилтэд нэвтрүүлэх
	<p>29.7. Эрүүл мэндийн санхүүжилтийн эх үүсвэр бүрийг нэгдсэн мэдээллийн санд бүртгэх, хянах, тайлагнах тогтолцоог санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран баталж, хэрэгжилтийг хангана</p>	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн санхүүжилтийн эх үүсвэрүүдийг нэгдсэн мэдээллийн санд бүртгэх шаардлага, аргачлалыг тодорхойлох - Нэгдсэн мэдээллийн сангийн бүртгэл, хяналт, тайлагналын тогтолцоог санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран боловсруулах - Тогтолцоог батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

		<ul style="list-style-type: none"> - Санхүүжилтийн мэдээллийн бүртгэл, хяналт, тайлагналын хэрэгжилтэд хяналт тавих
	<p>52.2. шаардлагатай тохиолдолд хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх асуудлаар бусад салбарын төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах, санал хүргүүлэх, хамтарсан арга хэмжээ, хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулна</p>	<ul style="list-style-type: none"> - Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх асуудлыг тодорхойлох, үнэлэх - Бусад салбарын төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагатай хамтын ажиллагааг зохион байгуулах - Хамтарсан санал, арга хэмжээ, хөтөлбөрийн төслийг боловсруулах - Хамтарсан арга хэмжээ, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах - Хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг үнэлэх
	<p>14⁵.5. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд эрүүл мэндийн чанарын хяналтын орон тооны бус зөвлөл ажиллуулж болох бөгөөд зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална</p>	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн чанарын хяналтын орон тооны бус зөвлөл байгуулах шаардлага, үндэслэлийг тодорхойлох - Зөвлөлийн дүрэм, үйл ажиллагааны зохицуулалтын төслийг боловсруулах - Зөвлөлийн бүрэлдэхүүнийг санал болгох, бүрдүүлэх ажлыг зохион байгуулах - Зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах - Зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих
<p>Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн</p>	<p>15.1.2. эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал, хэрэгцээг үнэлэх - Хүний нөөцийн хөгжлийн бодлогын зорилт, чиглэлийг тодорхойлох - Бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, арга хэмжээг боловсруулах - Бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, хангуулах
	<p>15.1.3. эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааны хэрэгцээ, нөхцөл байдлыг үнэлэх - Нийгмийн баталгааг хангах бодлого, арга хэмжээний санал боловсруулах - Холбогдох төрийн болон бусад байгууллагатай хамтран шийдвэр гаргах

		<ul style="list-style-type: none"> - Батлагдсан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах
	<p>15.1.6. хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг салбарын хэмжээнд төлөвлөх, зохион байгуулах, эрүүл мэндийн байгууллагын байршил, бүтэц, зохион байгуулалт, тусламж, үйлчилгээний төрөл, шатлал, эмнэлгийн болон сувиллын орны дээд хязгаарыг тогтоох</p>	<ul style="list-style-type: none"> - Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээ, ачааллыг үнэлэх - Салбарын хэмжээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлөвлөлт хийх - Эрүүл мэндийн байгууллагын байршил, бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлох - Тусламж, үйлчилгээний төрөл, шатлал болон эмнэлгийн, сувиллын орны дээд хязгаарыг тогтоох
	<p>15.1.9. хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих</p>	<ul style="list-style-type: none"> - Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх болон эрт илрүүлэх үйл ажиллагааны хэрэгцээг тодорхойлох - Үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны журмын төслийг боловсруулах - Журмыг батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах - Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих
	<p>15.1.10. аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, эмнэлгийн даргад тавигдах мэргэжлийн шаардлагыг тогтоох</p>	<ul style="list-style-type: none"> - Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга болон эмнэлгийн даргын албан тушаалын чиг үүрэг, хариуцлагыг тодорхойлох - Тухайн албан тушаалд тавигдах мэргэжлийн боловсрол, мэргэшил, туршлагын шаардлагыг тогтоох - Мэргэжлийн шаардлагын стандартыг батлах, мөрдүүлэх
	<p>15.1.11. аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын даргыг энэ хуулиар тогтоосон шаардлага болон Төрийн албаны тухай хуульд заасан сонгон шалгаруулалтын шалгалтын дүнг үндэслэн томилж, хуульд заасны дагуу чөлөөлөх</p>	<ul style="list-style-type: none"> - Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын даргад тавигдах хуульд заасан шаардлагыг хангуулах - Төрийн албаны тухай хуульд заасан сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, дүнг гаргах - Сонгон шалгаруулалтын дүн болон хуульд заасан шаардлагыг үндэслэн томилгоог шийдвэрлэх - Албан тушаалтныг хуульд заасан үндэслэл, журмын дагуу чөлөөлөх
дотоод аудит, үнэлгээ эрсдэлийн үнэлгээ хийх, зөрчил, дутагдлыг бүртгэх, шинжлэх;	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийх	88,350	96,000	0.920313
	Илэрсэн зөрчил, дутагдлыг бүртгэх, ангилах	141,360	96,000	1.4725
	Зөрчил, дутагдлын шалтгаан, үр дагаврыг шинжлэх	123,690	96,000	1.288438
	зөрчил, дутагдлыг арилгах болон давтан гарахаас урьдчилан сэргийлэх арга	Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний шаардлагыг тодорхойлох	159,030	96,000

хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулах, хэрэгжилтийг хянах, хаалтын нотолгоог бүрдүүлэх;	Давтан гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулах	176,700	96,000	1.840625
	Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, явцад хяналт тавих	70,680	96,000	0.73625
	Зөрчил арилсан эсэхийг нотлох баримт, хаалтын нотолгоог бүрдүүлэх	88,350	96,000	0.920313
ажилтны сургалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	Ажилтны сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох	123,690	96,000	1.288438
	Чанар, өвчтөний аюулгүй байдалтай холбоотой сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах	212,040	96,000	2.20875
	Сургалт, дадлага, зааварчилгааг зохион байгуулах	141,360	96,000	1.4725
	Урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх (эрсдэлийг бууруулах сургалт, мэдээлэл, зөвлөмж)	106,020	96,000	1.104375
	Сургалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг үнэлэх, сайжруулах санал боловсруулах	70,680	96,000	0.73625
	Дотоод хяналтаар илэрсэн зөрчил, дутагдлыг эрүүл мэндийн байгууллага нь тухай бүр арилгаж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж хэрэгжүүлнэ.	Дотоод хяналтаар илэрсэн зөрчил, дутагдлыг бүртгэх, ангилах	106,020	96,000
Зөрчил, дутагдлын шалтгаан, нөхцөлийг тодорхойлох		141,360	96,000	1.4725

	Зөрчлийг тухай бүр арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх	159,030	96,000	1.656563
	Давтан гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	212,040	96,000	2.20875
Эрүүл мэндийн байгууллага				35.9

Дээрхээс дүгнэвэл, Монгол Улсын Их Хурал 0.8, Засгийн Газар 2.26, Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага 10.9, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 15, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл 3.4, Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага 8.2, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага 10, Аймаг, нийслэлийн Засаг дарга 2.8, Нутгийн өөрөө удирдах байгууллага 2.4, Эрүүл мэндийн байгууллага 35.9 нийтдээ төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд **91.66** хүний нөөцийн хэрэгцээ бий болоод байна.

1.3. Гарах зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төсөлд улмаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардалийг юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Засгийн газар болон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан хаагчдын цалинг сард дунджаар 2,050,000³, жилд 24,600,000 гэж тооцон, эрүүл мэндийн байгууллагын ажилтан албан хаагч, эмчийн цалинг сард дунджаар 1,438,200⁴, жилд 17,258,400 гэж тооцлоо. Мөн засаг дарга, нутгийн өөрөө

³ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355342347221&showType=1>

⁴ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ДООД ХЭМЖЭЭ, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355342470971&showType=1>

удирдах байгууллагын албан хаагчдын цалинг сард дунджаар 2,087,000⁵, жилд 25,044,000 гэж тооцлоо.

Энэ зардлаа дээр тооцож гаргасан **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Хүснэгт 5. Төрийн байгууллагын стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал
Монгол Улсын Их Хурал	0.8	24,600,000	19,680,000
Засгийн Газар	2.26	24,600,000	55,596,000
Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	10.9	24,600,000	268,140,000
Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	15	24,600,000	369,000,000
Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл	3.4	24,600,000	83,640,000
Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	8.2	24,600,000	201,720,000
Эмнэлгийн тусламж, үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	10	24,600,000	246,000,000
Аймаг, нийслэлийн Засаг дарга	2.8	25,044,000	70,123,200
Нутгийн өөрөө удирдах байгууллага	2.4	25,044,000	60,105,600
Эрүүл мэндийн байгууллага	35.9	17,258,400	619,576,560
Нийт			1,993,581,360

1.4. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна.

⁵ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 12 дугаар хавсралт УЛС ТӨРИЙН АЛБАН ТУШААЛ ЭРХЭЛДЭГ ЗАРИМ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ,

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355342719221&showType=1>

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Төрийн байгууллагын нэг ажилтанд ногдох материаллаг зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, хүний нөөцийн нэмэгдсэн ажлын ачаалалд ногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 6. Төрийн байгууллага, түүний албан хаагчид ногдох материаллаг зардал

Зардлын төрөл	Зардлын нэр	1 жилд зарцуулах зардал (төгрөгөөр)
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285
	Шуудан холбоо	167,881
	Компьютер, тоног төхөөрөмж	3,351,757
	Тавилга, эд хогшил	53,725
Зардал	Түлш, халаалт	199,897
	Гэрэл, цахилгаан	937,251
	Цэвэр, бохир ус	51,947
	Урсгал засвар	53,725
	Газрын төлбөр	1411
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	356,555
	Тавилга, эд хогшил	100,000
Нэг албан хаагчид ногдох нийт зардал		5,395,434
Төрийн чиг үүрэг, түүний албан хаагчид /91.66/ ногдох зардал		494,545,480
Нийт		494,545,480

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 7. Төрийн байгууллагын чиг үүрэг, түүний албан хаагчдын нийт зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал (хүний тоо)	Хүний нөөцийн зардал (төгрөгөөр)	Материаллаг зардал (төгрөгөөр)	Нийт
Төрийн байгууллагын чиг үүрэг, түүний албан хаагчид	91.66	1,993,581,360	494,545,480	2,488,126,840
Нийт				2,488,126,840

Уг хуулийн төсөл хэрэгжиж эхэлснээр төрийн байгууллага, түүний албан хаагчдын хүний нөөцийн цалингийн зардалд нийт **1,993,581,360** төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд **494,545,480** төгрөг, нийт **2,488,126,840** /Хоёр тэрбум дөрвөн зуун наян найман сая нэг зуун хорин зургаан мянга найман зуун дөч/ төгрөгийн зардал үүсэхээр байна.

Энэхүү зардал нь хуулийн төсөл батлагдахтай холбоотойгоор үүсэх төрийн байгууллагын чиг үүрэг буюу үйлчилгээний нэмэлт ачаалал, хүний нөөц, түүнд тулгуурласан материаллаг зардал юм. Харин санхүүжилтын тухайд Монгол Улсын эрүүл мэндийн салбарын нийт зардал 2025 онд 2,776.9 их наяд төгрөг (ДНБ-ийн 3.1%), 2026 онд 3,430.3 их наяд төгрөг (ДНБ-ийн 3.4%) байхаар төлөвлөгдсөн байна. Харин хуулийн төсөл батлагдсаны дараа 2027 оны байдлаар эрүүл мэндийн салбарын нийт зардал 4.789 их наяд төгрөг (ДНБ-ийн 3.4%) болох тооцоо байх ба энэ нь өмнөх оноос 39.6%-иар өсөхөөр тооцоог гаргасан байна. Энэ тухайн хуулийн төсөл батлагдсанаар 1.359 их наядын санхүүжилт буюу улсын төсөвт зардал шинээр үүсэхээр байна.

1.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

1.2.4.1. Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх;

Төрийн байгууллагын зардал тооцох хүрээнд, хуулийн төсөлд тусгасан чиг үүргийг тухайн төрийн байгууллага жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог “тохиолдлын тоо” гэж авч үздэг. Эрүүл мэндийн байгууллагын тоог хамгийн өндрөөр авсан тул тухайн тохиолдлын тоог бууруулах боломжтой.

1.2.4.2. Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Аймаг, нийслэлийн Засаг дарга, Нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөвлөгөөг боловсруулах, батлахтай холбоотой үйл ажиллагаа нь 4 жилд 1 удаа байж болох учир давтамжийн тоо буурах боломжтой. Харин бусад үйл ажиллагааг хамгийн багаар буюу жилд 1 байхаар тогтоосон тул мэдээлэл хүргүүлэх давтамжийн тоог бууруулах боломжгүй.

1.2.4.3. Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;

Төрийн байгууллагууд чиг үүргийг гүйцэтгэхдээ зарцуулах хугацааг тогтоохдоо тухайн Эрүүл мэндийн тухай хууль нь суурь хууль тул тус үйл ажиллагааг хамгийн их хугацаанд гүйцэтгэхээр тогтоосон тул үүнийг илүү хурдан шуурхай явуулж зарцуулах хугацааг бууруулах боломжтой.

1.2.4.4. Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;

Төрийн байгууллагуудын гүйцэтгэх чиг үүрэг болох тайлан боловсруулах, хэлэлцүүлэг хийх зэрэг үйл ажиллагааг цахимаар хэрэгжүүлэх боломжтой ба ингэснээр зарцуулах хугацаа буурах боломжтой.

1.2.4.5. Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх;

Төрийн байгууллагын мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжгүй.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Хуулийн төсөлд зардлын тооцоо хийх нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох зорилготой байдаг. Эрүүл мэндийн тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд төрд учрах зардлыг урьдчилан тодорхойлох, цаашид ачааллыг аль болох багасгах санал боловсруулах зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэлээ.

Нэг. Төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо

Монгол Улсын Их Хурал 0.8, Засгийн Газар 2.26, Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага 10.9, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 15, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл 3.4, Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага 8.2, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага 10, Аймаг, нийслэлийн Засаг дарга 2.8, Нутгийн өөрөө удирдах байгууллага 2.4, Эрүүл мэндийн байгууллага 35.9 нийтдээ төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд **91.66** хүний нөөцийн хэрэгцээ бий болоод байна.

Уг хуулийн төсөл хэрэгжиж эхэлснээр төрийн байгууллага, түүний албан хаагчдын хүний нөөцийн цалингийн зардалд нийт **1,993,581,360** төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд **494,545,480** төгрөг, нийт **2,488,126,840** /Хоёр тэрбум дөрвөн зуун наян найман сая нэг зуун хорин зургаан мянга найман зуун дөч/ төгрөгийн зардал үүсэхээр байна.

Энэхүү зардал нь хуулийн төсөл батлагдахтай холбоотойгоор үүсэх төрийн байгууллагын чиг үүрэг буюу үйлчилгээний нэмэлт ачаалал, хүний нөөц, түүнд тулгуурласан материаллаг зардал юм. Харин санхүүжилтийн тухайд Монгол Улсын эрүүл мэндийн салбарын нийт зардал 2025 онд 2,776.9 их наяд төгрөг (ДНБ-ийн 3.1%), 2026 онд 3,430.3 их наяд төгрөг (ДНБ-ийн 3.4%) байхаар төлөвлөгдсөн байна. Харин хуулийн төсөл батлагдсаны дараа 2027 оны байдлаар эрүүл мэндийн салбарын нийт зардал 4.789 их наяд төгрөг (ДНБ-ийн 3.4%) болох тооцоо байх ба энэ нь өмнөх оноос 39.6%-иар өсөхөөр тооцоог гаргасан байна. Энэ тухайн хуулийн төсөл батлагдсанаар 1.359 их наядын санхүүжилт буюу улсын төсөвт зардал шинээр үүсэхээр байна.

Төрийн байгууллагын зардал тооцох хүрээнд, хуулийн төсөлд тусгасан чиг үүргийг тухайн төрийн байгууллага жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог “тохиолдлын тоо” гэж авч үздэг. Эрүүл мэндийн байгууллагын тоог хамгийн өндрөөр авсан тул тухайн тохиолдлын тоог бууруулах боломжтой.

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Аймаг, нийслэлийн Засаг дарга, Нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөвлөгөөг боловсруулах, батлахтай холбоотой үйл ажиллагаа нь 4 жилд 1 удаа байж болох учир давтамжийн тоо буурах боломжтой. Харин бусад үйл ажиллагааг хамгийн багаар буюу жилд 1 байхаар тогтоосон тул мэдээлэл хүргүүлэх давтамжийн тоог бууруулах боломжгүй.

Төрийн байгууллагууд чиг үүргийг гүйцэтгэхдээ зарцуулах хугацааг тогтоохдоо тухайн Эрүүл мэндийн тухай хууль нь суурь хууль тул тус үйл ажиллагааг хамгийн их хугацаанд гүйцэтгэхээр тогтоосон тул үүнийг илүү хурдан шуурхай явуулж зарцуулах хугацааг бууруулах боломжтой.

Төрийн байгууллагуудын гүйцэтгэх чиг үүрэг болох тайлан боловсруулах, хэлэлцүүлэг хийх зэрэг үйл ажиллагааг цахимаар хэрэгжүүлэх боломжтой ба ингэснээр зарцуулах хугацаа буурах боломжтой.

Төрийн байгууллагын мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжгүй.

ХОЁР. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛ

Энэ хэсэгт, Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах улсын болон орон нутгийн төсвийн урсгал зардлын тооцоог хийхдээ эрүүл мэндийн салбарын өнөөгийн санхүүжилтийн бүтэц, улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангийн оролцоо, орон нутгийн төсвийн зарлагын чиг хандлага, мөн хуулийн төсөлтэй холбоотойгоор шинээр бий болох зохицуулалтын санхүүгийн хэрэгцээг харгалзан үзэв.

Энэхүү тооцоо, шинжилгээний хүрээнд Эрүүл мэндийн тухай хуулийн өөрчлөлтийн санхүүжилтийн нэгтгэлийг боловсруулж, холбогдох аргачлалын дагуу санхүүжилтийн бодолт, тооцоог хийсэн болно. Мөн эрүүл мэндийн салбарын төсвийн ДНБ-д эзлэх хувь, Эрүүл мэндийн яамны үндсэн үзүүлэлт, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага, даатгуулагчийн бүтэц, сангийн зарлагын бүтэц зэрэг үзүүлэлтүүдийг ашиглан салбарын санхүүгийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийв. Үүний зэрэгцээ Монгол Улсын нэгдсэн төсвийн онцгой татварын орлого болон аймаг, нийслэлийн орон нутгийн төсвийн зарлагын мэдээллийг авч үзэн, хуулийн төслийн хэрэгжилттэй холбоотой санхүүгийн ачаалал, эх үүсвэрийн боломжийг тодорхойлохыг зорилоо.

Түүнчлэн дээрх судалгаа, тооцоонд үндэслэн хуулийн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн ерөнхий хэрэгцээ, үе шаттай хэрэгжилтийн боломж, цаашид эрүүл мэндийн салбарын санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах арга хэмжээний талаар дүгнэлт, санал боловсруулав.

Эрүүл мэндийн тухай хуулийн төслийн санхүүжилтийн нөлөөллийг дараах байдлаар дэлгэрэнгүй харуулав.

2.1. Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн санхүүжилтийн нэгтгэл

Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой санхүүжилтийг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын гишүүн орнуудад өгч буй зөвлөмж, хүн амын хэрэгцээ, шаардлагад үндэслэн эрүүл мэндийн тогтолцооны үндсэн чиг үүрэг, тусламж, үйлчилгээний багц, хүн амын хамрагдалт, даатгалын тогтолцоо, нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ, хөрөнгө оруулалт болон салбарын удирдлагын зардлыг хамруулан тооцлоо.

Санхүүжилтийн нэгтгэлийг боловсруулахдаа эрүүл мэндийн даатгалын сан, улсын төсөв, орон нутгийн төсөв, онцгой албан татварын орлого, эмийн татвар, гадаадын зээл, тусламж зэрэг олон эх үүсвэрийг хамруулж, тус бүрийн зориулалт, зарцуулалтын урсгал, санхүүжилтийн тогтолцоог уялдуулан тооцсон болно. Мөн зардлын тооцоог 2025 оны жилийн эцсийн хүн амын статистик мэдээлэл, эрүүл мэндийн даатгалын хамрагдалт, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, тусламж, үйлчилгээний багц, эмчилгээний удирдамж, дархлаажуулалт болон эрт илрүүлгийн товлал, төсвийн болон хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт үндэслэн боловсруулав.

Санхүүжилтийн бүтцээс үзэхэд Эрүүл мэндийн сайдын багцад хамаарах нийт зардлын хамгийн өндөр хувийг эрүүл мэндийн даатгалын сангаар дамжин хэрэгжих даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээ болон төрөөс хариуцах иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ эзэлж байна. Тухайлбал, нийт даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний үйлчилгээ (анхан шатлалын тусламж, үйлчилгээг хамааруулаагүй)-нд зарцуулж буй нийт зардлын гүйцэтгэл 2025 оны байдлаар 64.2 хувь (1,781.9 тэрбум төгрөг)-ийг эзэлж байгаа нь эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоонд лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ хэт давамгайл байгааг харуулж байна.

Анхан шатлалын тусламж, үйлчилгээний зардал нийт санхүүжилтийн 18.4 хувь (513.2 тэрбум төгрөг), нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо, арга хэмжээ, тандалт, эрт илрүүлэг, дархлаажуулалт, салбар дундын үйл ажиллагааны зардал нийт санхүүжилтийн 4.4 хувь (113.0 тэрбум төгрөг)-ийг тус тус эзэлж байгаа нь эрүүл мэндийн тогтолцоог хүн төвтэй, урьдчилан сэргийлэх чиглэлд суурилсан тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлэх бодлоготой төдийлөн уялдаж чадахгүй байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бол зөвхөн нийгмийн зардал биш бөгөөд эдийн засгийн чухал хөрөнгө оруулалт юм. Эрүүл хүн ам нь хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж, эмчилгээний дараагийн зардлыг бууруулдаг. Мөн урьдчилан сэргийлэх үйлчилгээ нь хожим үүсэх өндөр өртөгтэй оношилгоо, эмчилгээ, хяналтаас зайлсхийх үндсэн нөхцөл болдог тул Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас улс орнуудад эрүүл мэндийн салбарт дотоодын нийт бүтээгдэхүүний 5-6%-иас доошгүй хувийг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогоос зарцуулахыг зөвлөдөг. Энэ нь “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтыг” хангах наад захын босго гэж тооцогддог. Монгол Улсын хувьд улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогоос 2025 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 3.1 хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулж байна. Энэ нь хүн амыг өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл, чанартай амьдрах тогтолцоог бүрдүүлэх бус өвдсөн хойно нь үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд боломжит эх үүсвэрийг зарцуулах тогтолцоо юм.

Хуулийн төсөлд эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх, эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг тогтмол эх үүсвэр тооцдог аргачлалтай болгох, анхан шатлалын тусламж, үйлчилгээний санхүүжилтийн нийт зардалд эзлэх хувийг дээшлүүлэх, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах зэрэг нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх, орон нутгийн төсвийн үүрэг оролцоог сайжруулах зорилтуудыг тусгасан.

Архи, тамхи, чихэрлэг бүтээгдэхүүний онцгой албан татвар болон эмийн импортын татварын тодорхой хувийг нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнд чиглүүлэхээр тусгасан нь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөгч хүчин зүйлсийн эсрэг хариу арга хэмжээ авах, хүн амын эрүүл мэндийн зан үйлийг өөрчлөх, дэмжих, хамгаалах орчин бүрдүүлэх, салбарын тандалт, эрдэм шинжилгээ, судалгаа тооцоолол хийхэд чухал ач холбогдолтой юм.

Хөрөнгө оруулалтын зардлын хувьд улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрийг ашиглан эрүүл мэндийн байгууллагын дэд бүтэц, тоног төхөөрөмж, мэдээллийн систем, лабораторийн хүчин чадал, шинэ технологи болон инновацийн хөгжүүлэлтийг үе шаттайгаар санхүүжүүлэхээр тооцлоо. Түүнчлэн салбарын бодлого, удирдлага, хүний нөөцийн хөгжүүлэлт, төгсөлтийн дараах сургалт, нэгдсэн мэдээллийн сан, судалгаа, шинжилгээний тогтолцоог бэхжүүлэхэд шаардагдах зардлыг улсын төсвийн хүрээнд тусгав.

Тооцооллоор, Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэх нийт санхүүжилтийн хэрэгцээ 2025 онд 2,776.9 тэрбум төгрөг, 2026 онд 3,430.3 тэрбум төгрөг, 2027 онд 4,800.3 тэрбум төгрөг, 2028 онд 5,655.6 тэрбум төгрөг байхаар тооцогдож байна. Энэ нь дотоодын нийт бүтээгдэхүүний 2025 онд 3.1 хувь, 2026 онд 3.4 хувь, 2027 онд 4.4 хувь, 2028 онд 4.9 хувьтай тэнцэх хэмжээний санхүүжилтийн хэрэгцээ үүсэхээр байгааг харуулж байна.

Ийнхүү эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг үе шаттайгаар нэмэгдүүлэх нь иргэдийн санхүүгийн эрсдэлийг бууруулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар,

хүртээмжийг сайжруулах, анхан шатлал болон нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, улмаар эрүүл мэндийн тогтолцооны урт хугацааны тогтвортой байдлыг хангах суурь нөхцөл болно.

/Дор дурдсан хүснэгтүүдэд дурдсан нарийвчилсан тооцоог энэхүү судалгааны тайланд хавсаргасан хавсралт MS Excel файлаас үзнэ үү./

Хүснэгт 2.1. Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн санхүүжилтийн нэгтгэл

Зардлын үндсэн ангилал	2025 он (тэрбум төгрөг)	2026 он (тэрбум төгрөг)	Нийт зардалд эзлэх хувь (2026 он)	Гол санхүүжилтийн эх үүсвэр
Даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээ	1,021.4	1,248.5	36.3%	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл
Төр хариуцах иргэдийн тусламж, үйлчилгээ	760.6	885.0	25.4%	Улсын төсөв
Анхан шатлалын тусламж, үйлчилгээ	513.2	613.2	17.9%	Улсын төсөв
Нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ, тогтолцооны зардал	113.0	105.9	3.1%	Улсын болон орон нутгийн төсөв
Хөрөнгө оруулалтын зардал	181.7	417.5	12.2%	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж
Эрүүл мэндийн бодлого, удирдлага болон бусад	187.2	160.2	4.7%	Улсын төсөв
Нийт дүн	2,776.9	3,430.3	100.0%	
ДНБ-д эзлэх хувь	3.1%	3.4%		

Хүснэгт 2.2. Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн санхүүжилтийн өсөлтийн төсөөлөл

Үзүүлэлт	2025 он	2026 он	2027 он	2028 он
Нийт санхүүжилтийн хэрэгцээ (тэрбум төгрөг)	2,776.9	3,430.3	4,800.3	5,655.6
Өмнөх оноос өссөн дүн (тэрбум төгрөг)	—	653.4	1,370.0	855.2
Өсөлтийн хувь	—	23.5%	39.9%	17.8%
ДНБ-д эзлэх хувь	3.1%	3.4%	4.4%	4.9%

2.2. Санхүүжилтийн бодолт, тооцоо

Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн санхүүжилтийн бодолт, тооцоог боловсруулахдаа эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, улсын төсвийн санхүүжилт, хүн амын өсөлтийн төсөөлөл, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, даатгуулагчийн бүтэц, төрөөс хариуцах иргэдийн тоо, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц зэрэг үндсэн үзүүлэлтүүдийг харгалзан үзэв.

Эрүүл мэндийн салбарын нийт санхүүжилт 2024 оны 2.5 их наяд төгрөгөөс 2026 онд 3.4 их наяд төгрөг хүртэл өссөн байна. Өсөлтийн гол эх үүсвэр нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого, төрөөс хариуцах иргэдийн шимтгэлийн санхүүжилт, улсын төсвийн нэмэгдэл санхүүжилт байна. Уг өсөлт эрүүл мэндийн салбарын албан хаагчдын цалин хөлсний нэмэгдэл, эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн өсөлт болон эрүүл мэндийн даатгалын сангийн хуримтлагдсан өглөгтэй шууд холбоотой.

Хуулийн төсөлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого өсөхтэй уялдан эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого үе шаттайгаар нэмэгдэхээр тооцогдсон болно. Мөн хүн амын өсөлт, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, төрөөс шимтгэлийг нь хариуцах иргэдийн тоо, анхан шатлалын тусламж үйлчилгээний санхүүжилтийн хэрэгцээ зэрэг үзүүлэлтэд үндэслэн эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын бүтэц болон тусламж, үйлчилгээний зардлын төсөөллийг боловсруулав. Үүнээс гадна эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг даатгуулагчийн төрлөөр ангилан тооцож, салбарын санхүүгийн тогтвортой байдлыг дунд хугацаанд үнэлэх боломжийг бүрдүүлсэн болно.

Хүснэгт 2.3. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн эх үүсвэр (тэрбум төгрөгөөр)

Эх үүсвэр	2024 он	2025 он	2026 он
ЭМД-ын сан /шимтгэл/	846.9	1,021.4	1,248.5
Төр хариуцах иргэдийн шимтгэл	324.1	352.2	431.2
Улсын төсвийн санхүүжилт	1,334.6	1,367.6	1,556.8
Гадаадын зээл, тусламж	32.5	35.7	193.8
Нийт	2,538.0	2,776.9	3,430.3

Хүснэгт 2.4. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон шимтгэлийн тооцоолол (төгрөгөөр)

Үзүүлэлт	2024 он	2025 он	2026 он	2027 он	2028 он
Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ	660,000	792,000	792,000	792,000	950,400
ХХДХ-ний 1 хувь /сар/	6,600	7,920	7,920	7,920	9,504
ХХДХ-ний 3 хувь /сар/	19,800	23,760	23,760	23,760	28,512
ХХДХ-ний 6 хувь /сар/	39,600	47,520	47,520	47,520	57,024

Хүснэгт 2.5. Хүн ам болон даатгуулагчийн тооны төсөөлөл (хүнээр)

Үзүүлэлт	2024 он	2025 он	2026 он	2027 он	2028 он
Нийт хүн амын тоо	3,554,550	3,591,120	3,648,577	3,706,954	3,766,265
Монгол Улсад оршин суугаа хүн амын тоо	3,419,193	3,437,000	3,481,681	3,526,942	3,572,792
Ажилтан болон ажил олгогч	770,923	793,592	793,592	793,592	793,592
Иргэн өөрөө хариуцан төлөгч	442,608	449,058	472,114	499,372	527,158
Шимтгэлийг төр хариуцах иргэн	2,291,210	2,302,185	2,335,846	2,366,212	2,396,972

Хүснэгт 2.6. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын бүтэц (тэрбум төгрөгөөр)

Орлогын төрөл	2024 он	2025 он	2026 он	2027 он	2028 он
Ажилтан /албан сектор/	812.7	977.2	1,191.0	1,310.1	1,441.1
Иргэн өөрөө шимтгэл төлөгч	34.2	44.1	57.5	125.5	184.9
Шимтгэлийг нь төр хариуцах иргэд	324.1	352.2	431.2	1,347.5	1,638.0
Төр хариуцах тусламж, үйлчилгээ	259.3	408.4	453.8	-	-
Анхан шатлал	487.5	513.2	613.2	1,005.6	1,222.4
Нийт	1,917.8	2,295.1	2,746.7	3,788.7	4,486.4

2.3. Эрүүл мэндийн салбарын төсөв ДНБ-д эзлэх хувь

Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн санхүүжилтийн хэрэгцээ нь дотоодын нийт бүтээгдэхүүн болон улсын төсвийн өсөлттэй уялдан үе шаттайгаар нэмэгдэхээр тооцогдож байна. Тухайлбал, эрүүл мэндийн салбарын нийт төсөв 2021 онд ДНБ-ий 4.6 хувь (Цар тахлын үеийн нөлөөлөл)-тай тэнцэж байсан бол 2024 онд 3.1 хувь, 2026 онд 3.4 хувь байсан бөгөөд хуулийн төслийн шинэчлэлийн хүрээнд 2027–2028 онд 4.4–4.9 хувьд хүрэх төсөөлөлтэй байна.

Мөн эрүүл мэндийн салбарын төсөв улсын нэгдсэн төсөвт эзлэх хувь 2024 оны 8.3 хувиас 2028 онд 14.9 хувь хүртэл өсөхөөр байгаа нь эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн ач холбогдлыг нэмэгдүүлж, төрөөс энэ салбарт чиглүүлэх хөрөнгө оруулалт, урсгал санхүүжилтийг үе шаттайгаар өргөжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Үүнд эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, анхан шатлалын тусламж үйлчилгээ, хөрөнгө оруулалт болон нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээний санхүүжилтийн өсөлт голлон нөлөөлж байна. Энэхүү өсөлт нь иргэдээр авахуулж буй эм, эмнэлгийн хэрэгсэл болон албан бус

төлбөрийг бууруулах, эрүүл мэндийн салбарын эмч, ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн салбарын шинэлчлэлийг бататгах, эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцлийг хангах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих тогтолцоог сайжруулахад чухал ач холбогдолтой.

Хүснэгт 2.7. Эрүүл мэндийн салбарын төсөв ДНБ-д эзлэх хувь
(тэрбум төгрөгөөр)

Он	ДНБ	Эрүүл мэндийн салбарын нийт төсөв	ДНБ-д эзлэх хувь	Улсын нийт төсөвт эзлэх хувь
2021 он	43,555.5	1,999.3	4.6%	12.8%
2022 он	53,851.5	1,857.3	3.4%	10.2%
2023 он	70,441.5	2,031.6	2.9%	9.0%
2024 он	80,663.1	2,538.0	3.1%	8.3%
2025 он	89,037.1	2,776.9	3.1%	8.7%
2026 он	102,257.2	3,430.3	3.4%	10.4%
2027 он	108,699.4	4,789.0	4.4%	13.8%
2028 он	115,764.9	5,638.7	4.9%	14.9%

Хүснэгт 2.8. Эрүүл мэндийн салбарын төсвийн үндсэн бүтэц
(тэрбум төгрөгөөр)

Үзүүлэлт	2024 он	2025 он	2026 он	2027 он	2028 он
Эх үүсвэр					
ЭМД-ын сан	846.9	1,021.4	1,248.5	1,435.6	1,626.0
Улсын төсөв	1,658.7	1,719.8	1,988.0	3,141.8	3,773.3
Зээл, тусламж	32.5	35.7	193.8	222.9	256.3
Зардлын төрөл					
Хөрөнгө оруулалт	282.6	145.9	223.7	268.4	322.1
Урсгал төсөв	1,376.0	1,574.0	1,764.4	2,873.8	3,450.9
Нийт	2,538.0	2,776.9	3,430.3	4,789.0	5,638.7

2.4. Эрүүл мэндийн салбарын төсвийн үндсэн үзүүлэлт

Эрүүл мэндийн салбарын төсвийн үндсэн үзүүлэлтүүдээс харахад сүүлийн жилүүдэд салбарын санхүүжилт дотоодын нийт бүтээгдэхүүн болон улсын төсөвтэй уялдан тогтмол өсөх хандлагатай байна. Тухайлбал, эрүүл мэндийн салбарын нийт төсөв 2020 онд 1.3 их наяд төгрөг байсан бол 2026 онд 3.4 их наяд төгрөг батлагдсан бөгөөд 2027–2028 онд 4.8–5.6 их наяд төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна.

Үүнтэй зэрэгцэн эрүүл мэндийн салбарын төсөв ДНБ-д эзлэх хувь 2024–2026 онд 3.1–3.4 хувьтай байгаа бол цаашид 5.0 хувийн зорилтот түвшинд хүргэх бодлогын чиглэл тусгагдсан байна. Мөн улсын нэгдсэн төсөвт эзлэх эрүүл мэндийн салбарын төсвийн хувь хэмжээ 2024 оны 8.3 хувиас 2028 онд 15.0 хувь хүртэл өсөхөөр тооцсон нь эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн ач холбогдлыг нэмэгдүүлж буйг харуулж байна.

Түүнчлэн нэг иргэнд ногдох эрүүл мэндийн төсөв 2020 онд 373.9 мянган төгрөг байсан бол 2028 онд 1.5 сая төгрөгт хүрэхээр байгаа бөгөөд ам.доллараар илэрхийлсэн дүнгээр 131.2 ам.доллараас 410.8 ам.доллар хүртэл өсөхөөр тооцоологджээ. Энэ нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх, анхан шатлал болон нийгмийн эрүүл мэндийн санхүүжилтийг бэхжүүлэх зорилготой нийцэж байна.

Хүснэгт 2.9. Эрүүл мэндийн салбарын төсвийн үндсэн үзүүлэлтүүд (тэрбум төгрөгөөр, өөрөөр зааснаас бусад тохиолдолд)

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он	2026 он	2027 он	2028 он
Дотоодын нийт бүтээгдэхүүн	37,453.3	43,555.5	53,851.5	70,441.5	80,663.1	89,037.1	102,257.2	108,699.4	115,764.9
Нэгдсэн төсөв	13,904.3	15,630.4	18,159.7	22,509.0	30,487.9	31,901.6	32,980.0	34,626.0	37,829.2
Эрүүл мэндийн салбарын нийт төсөв	1,255.4	1,999.3	1,857.3	2,031.6	2,538.0	2,776.9	3,430.3	4,800.3	5,655.6
ДНБ-д эзлэх эрүүл мэндийн салбарын төсвийн хувь	3.4%	4.6%	3.4%	2.9%	3.1%	3.1%	3.4%	4.4%	4.9%
Нэгдсэн төсөвт эзлэх эрүүл мэндийн салбарын төсвийн хувь	9.0%	12.8%	10.2%	9.0%	8.3%	8.7%	10.4%	13.9%	15.0%
Нийт хүн амын тоо (хүнээр)	3,357,542	3,409,939	3,457,548	3,504,741	3,554,550	3,591,120	3,626,403	3,706,954	3,766,265
Нэг иргэнд ногдох төсөв (мянган төгрөг)	373.9	586.3	537.2	579.7	714.0	773.3	940.2	1,294.9	1,501.6
Нэг иргэнд ногдох төсөв (ам.доллар)	131.2	205.8	156.6	169.4	208.9	217.9	264.0	359.7	405.8
ДНБ-д эзлэх анхан шатны тусламж, үйлчилгээний төсвийн хувь	0.7%	0.8%	0.7%	0.6%	0.8%	0.7%	0.7%	0.9%	1.1%

2.5. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэлээс үзэхэд сүүлийн жилүүдэд тус сангийн хэмжээ тогтмол өсөж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн үндсэн эх үүсвэрийн нэг болж байна. Ялангуяа 2021 оноос эхлэн эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд улсын төсвөөс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд олгох санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэн төвлөрүүлж, “Нэг худалдан авагчийн тогтолцоо”-нд шилжсэн нь сангийн орлого, зарлагын бүтэц болон хэмжээнд мэдэгдэхүйц өөрчлөлт авчирсан байна.

Тухайлбал, эрүүл мэндийн даатгалын сангийн нийт орлого 2018 онд 422.3 тэрбум төгрөг байсан бол 2024 онд 2.0 их наяд төгрөгт хүрч, 2026 онд 2.7 их наяд төгрөгт хүрэхээр батлагджээ. Үүний дотор ажил олгогч болон даатгуулагчийн төлөх шимтгэл хамгийн өндөр хувийг бүрдүүлж байгаа бөгөөд төрөөс шимтгэлийг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл, төрөөс санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний хөрөнгө мөн үе шаттайгаар өсөхөөр байна.

Зарлагын бүтцийн хувьд эрүүл мэндийн байгууллагуудад олгох тусламж, үйлчилгээний санхүүжилт нийт зардлын дийлэнх хэсгийг эзэлж байна. Мөн хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээг хязгаарлах, шаардлага багатай тусламж, үйлчилгээг бууруулах, архаг өвчний хяналтыг сайжруулах бодлоготой уялдуулан эмийн үнийн хөнгөлөлт нэмэгдэх хандлагатай байна. Түүнчлэн өмнөх оны өглөг болон нэмэлт санхүүжилтийн хэмжээ нь сангийн тогтвортой байдалд нөлөөлөх чухал хүчин зүйл болж байна.

Хүснэгт 2.10. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын бүтэц (тэрбум төгрөгөөр)

Үзүүлэлт	2018 он	2020 он	2022 он	2024 он	2025 он	2026 он
Ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэл	290.8	321.1	492.9	812.7	977.2	1,191.0
Төрөөс шимтгэлийг нь хариуцах иргэдийн шимтгэл	67.5	84.0	163.7	324.1	352.2	431.2
Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	16.5	15.6	25.2	34.2	44.1	—
Төрөөс олгох тусламж, үйлчилгээний санхүүжилт	—	—	540.4	746.8	921.6	1,067.0
Нэмэлт санхүүжилт	—	—	295.3	104.1	4.6	—
Нийт орлого	422.3	477.4	1,450.7	1,964.8	2,299.5	2,746.7

Хүснэгт 2.11. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын гүйцэтгэл (тэрбум төгрөгөөр)

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он	2026 он
----------	---------	---------	---------	---------	---------	---------	---------

Эрүүл мэндийн байгууллагуудад олгох тусламж, үйлчилгээний санхүүжилт	374.8	1,468.1	1,472.8	1,455.9	1,977.0	1,917.0	1,415.1
Эмийн үнийн хөнгөлөлтийн зардал	35.9	69.4	84.3	95.7	137.8	197.4	169.8
Үйл ажиллагааны урсгал зардал	4.8	8.7	14.7	10.9	15.1	13.8	13.5
Өмнөх оны өглөг	0.0	0.0	264.7	60.6	218.3	316.8	279.3
Нийт зарлага	415.7	1,546.3	1,571.8	1,780.9	2,129.4	2,128.2	2,458.8

2.6. Эрүүл мэндийн даатгал - даатгуулагчийн төрлөөр

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын бүтцээс үзэхэд даатгуулагчийн төрлөөс хамааран төвлөрөх шимтгэлийн хэмжээ харилцан адилгүй байна. Тухайлбал, цалин хөлснөөс шимтгэл төлөгч даатгуулагчид нийт орлогын хамгийн өндөр хувийг бүрдүүлж байгаа бол төрөөс шимтгэлийг нь хариуцах иргэдийн бүлэг мөн өндөр дүнтэй санхүүжилтийн эх үүсвэр болж байна.

Мөн хүүхэд, оюутан, тэтгэвэр авагч, сайн дурын даатгуулагч, малчин, амьжиргааны түвшин доогуур иргэд зэрэг бүлгүүдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс болон холбогдох эх үүсвэрээс санхүүжүүлж байгаа нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг хангах, санхүүгийн эрсдэлээс иргэдийг хамгаалах бодлоготой нийцэж байна.

Хүснэгт 2.12. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл - даатгуулагчийн төрлөөр (тэрбум төгрөгөөр)

Даатгуулагчийн төрөл	Даатгуулагчийн тоо /2025 он/	Шимтгэлийн дүн
Амьжиргааны түвшин доогуур иргэн	272,497	113.9
Гадаадын иргэн	854	0.6
Малчин	37,387	19.5
Оюутан	54,507	40.2
Тэтгэвэр авагч	572,152	577.4
Хорих байгууллагад хоригдож буй иргэн	4,741	0.6
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	95,051	74.8
Хүүхэд	1,371,550	273.7
Цалин хөлснөөс шимтгэл төлөгч	793,592	163.3

Цэрэг, хугацаат алба хаагч	5,407	0.4
Ээж	75,838	83.9
Нийт	3,283,576	1,348.4

2.7. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын бүтэц

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын бүтцээс үзэхэд лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бөгөөд нийт зардлын талаас илүүг бүрдүүлж байна. Үүний зэрэгцээ анхан шатлалын тусламж, үйлчилгээний санхүүжилтийн хэмжээ жилээс жилд өсөж байгаа нь эрүүл мэндийн тогтолцоог урьдчилан сэргийлэх, иргэнд ойр анхан шатны тусламжид суурилсан тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлэх бодлоготой нийцэж байна.

Мөн төр хариуцах эмийн зардал, эрт илрүүлэг, эмийн үнийн хөнгөлөлт, үйл ажиллагааны урсгал зардал зэрэг санхүүжилтийн чиглэлүүдийн бүтэц, эзлэх хувь жил бүр өөрчлөгдөж байгаа бөгөөд өмнөх оны өглөгийн хэмжээ нь сангийн зарлагын тодорхой хувийг эзэлж байна

2.8. Монгол Улсын нэгдсэн төсвийн онцгой татварын орлого

Эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үйл ажиллагааны тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор архи, тамхи, чихэрлэг бүтээгдэхүүн болон эрүүл мэндэд сөрөг нөлөө бүхий зарим бүтээгдэхүүний онцгой албан татварын орлогын тодорхой хэсгийг эрүүл мэндийн салбарт чиглүүлэх боломжийг судлав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын бүтцээс үзэхэд онцгой албан татварын орлого жил бүр тогтмол төвлөрч байгаа бөгөөд импортын болон дотоодын архи, тамхи, пиво, автомашин зэрэг бүтээгдэхүүнээс бүрдэж байна. Тухайлбал, 2025 оны байдлаар онцгой албан татварын нийт орлого 955.1 тэрбум төгрөг байхаар төсөөлөгдөж байгаа бөгөөд үүний дотор импортын архи, пиво, тамхины онцгой албан татвар хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Мөн эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд архи, тамхи, чихэрлэг бүтээгдэхүүн болон импортын зарим бүтээгдэхүүний онцгой албан татварын орлогын 20 хүртэлх хувийг нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ, эрт илрүүлэг, тандалт, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд үе шаттайгаар чиглүүлэх боломжтой гэж үзэв. Тухайлбал, 2025 оны тооцооллоор зарим сонгогдсон бүтээгдэхүүний онцгой албан татварын орлого 532.9 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүний 20 хувь нь 106.6 тэрбум төгрөгт хүрэхээр байна.

Хүснэгт 2.13. Монгол Улсын нэгдсэн төсвийн онцгой албан татварын орлого (тэрбум төгрөгөөр)

Үзүүлэлт	2023 он	2024 он	2025 он
Онцгой албан татварын нийт орлого	790.1	1,107.4	955.1
<i>Дотоодын архины татвар</i>	<i>213.4</i>	<i>234.2</i>	<i>247.1</i>

<i>Дотоодын тамхины татвар</i>	15.0	9.5	2.1
Автобензин, дизелийн түлшний татвар	13.2	3.7	4.4
<i>Импортын архи, пиво, тамхины татвар</i>	186.1	211.9	232.7
<i>Импортын пивоны татвар</i>	8.3	12.5	16.7
Суудлын автомашины татвар	321.0	582.1	417.7
<i>Дотоодын пивоны татвар</i>	32.5	53.4	33.4

Хүснэгт 2.14. Эрүүл мэндийн салбарт чиглүүлэх боломжтой онцгой албан татварын орлогын тооцоо
(тэрбум төгрөгөөр)

Үзүүлэлт	2025 он
Сонгогдсон бүтээгдэхүүний онцгой албан татварын нийт орлого	532.9
Эрүүл мэндийн салбарт чиглүүлэх боломжтой хувь	20%
Эрүүл мэндийн салбарт төвлөрүүлэх боломжтой эх үүсвэр	106.6

2.9. Орон нутгийн төсвийн зарлага аймаг, нийслэлээр

Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа, орон нутгийн түвшний урьдчилан сэргийлэх хөтөлбөр, эрт илрүүлэг болон салбар дундын арга хэмжээг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвийн оролцоог нэмэгдүүлэх шаардлага үүсэж байна.

Аймаг, нийслэлийн төсвийн зарлагын мэдээллээс үзэхэд 2025 оны байдлаар орон нутгийн төсвийн нийт зарлага 8.2 их наяд төгрөгт хүрэхээр байгаа бөгөөд үүнээс 0.5 хувийг эрүүл мэндийг дэмжих болон нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнд чиглүүлэхэд ойролцоогоор 40.8 тэрбум төгрөгийн нэмэлт эх үүсвэр бүрдэх боломжтой байна.

Тухайлбал, хамгийн өндөр санхүүгийн боломж Улаанбаатар хот, Өмнөговь аймаг, Төвийн бүс, Хангайн бүсэд төвлөрч байгаа бол хүн ам цөөн, төсвийн чадавх багатай аймаг, бүсүүдэд улсын төсвийн дэмжлэг шаардлагатай хэвээр байна. Иймд орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн тодорхой хувийг нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнд чиглүүлэх механизмыг үе шаттайгаар нэвтрүүлэх боломжтой гэж үзэв.

Хүснэгт 2.15. Орон нутгийн төсвийн зарлага, аймаг, нийслэлээр
(сая төгрөгөөр)

Аймаг, бүс	2023 он	2024 он	2025 он
------------	---------	---------	---------

Баруун бүс	277,464.0	416,934.0	409,495.0
Хангайн бүс	604,676.0	750,363.0	735,661.0
Төвийн бүс	1,328,703.0	2,466,662.0	2,210,929.0
Зүүн бүс	209,561.0	258,288.0	282,321.0
Улаанбаатар хот	1,915,903.0	3,361,854.0	4,525,620.0
Улсын дүн	4,336,306.0	7,258,570.0	8,164,025.0

Эх сурвалж: www.1212.mn /ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, аймаг, нийслэлээр, жилээр- 2025 он/

Хүснэгт 2.15. Орон нутгийн төсвийн 0.5 хувийг нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнд чиглүүлэх боломжит эх үүсвэр
(сая төгрөгөөр)

Аймаг, бүс	2025 оны төсөв	0.5 хувь
Баруун бүс	409,495.0	2,047.5
Хангайн бүс	735,661.0	3,678.3
Төвийн бүс	2,210,929.0	11,054.6
Зүүн бүс	282,321.0	1,411.6
Улаанбаатар хот	4,525,620.0	22,628.1
Нийт дүн	8,164,025.0	40,820.1

НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ

Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар үүсэх санхүүжилтийн нөлөөллийг нэгтгэн дүгнэвэл дараах байдалтай байна.

Нэг. Төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо

Монгол Улсын Их Хурал 0.8, Засгийн Газар 2.26, Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага 10.9, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 15, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл 3.4, Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага 8.2, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага 10, Аймаг, нийслэлийн Засаг дарга 2.8, Нутгийн өөрөө удирдах байгууллага 2.4, Эрүүл мэндийн байгууллага 35.9 нийтдээ төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд 91.66 хүний нөөцийн хэрэгцээ бий болоод байна.

Уг хуулийн төсөл хэрэгжиж эхэлснээр төрийн байгууллага, түүний албан хаагчдын хүний нөөцийн цалингийн зардалд нийт 1,993,581,360 төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд 494,545,480 төгрөг, нийт 2,488,126,840 (Хоёр тэрбум дөрвөн зуун наян найман сая нэг зуун хорин зургаан мянга найман зуун дөч) төгрөгийн зардал үүсэхээр байна.

Хоёр. Санхүүжилтийн нөлөөлөл

Монгол Улсын эрүүл мэндийн салбарын нийт зардал 2025 онд 2,776.9 их наяд төгрөг (ДНБ-ийн 3.1%), 2026 онд 3,430.3 их наяд төгрөг (ДНБ-ийн 3.4%) батлагдсан байна. Хуулийн төсөл батлагдсаны дараа 2027 оны байдлаар эрүүл мэндийн салбарын нийт зардал 4.789 их наяд төгрөг (ДНБ-ийн 4.4%) болох тооцоо байх ба энэ нь өмнөх оноос 39.9%-иар өсөхөөр тооцоог гаргасан байна. Тухайн хуулийн төсөл батлагдсанаар 1,370.0 тэрбум төгрөгийн санхүүжилт буюу улсын төсөвт зардал шинээр үүсэхээр байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан санхүүжилтийн зохицуулалтын дагуу:

- Эрүүл мэндийн салбарын нийт санхүүжилтийн хэмжээ тухайн жилийн ДНБ-ийн 5-аас доошгүй хувь байхаар тогтоосон нь 2028 оны байдлаар 5.7 орчим их наяд төгрөгт хүрэхээр тооцогдож байна;
- Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг ажил олгогч, ажилтан хамтран сард хөдөлмөрийн хөлсний 4-өөс доошгүй хувиар тооцох зохицуулалт нь санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах үндэс болно;
- Анхан шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн хэмжээ 2026 онд 613.2 тэрбум төгрөг байснаас 2028 онд 1,224.0 тэрбум төгрөгт хүрч 2 дахин өсөхөөр тооцогдож байна;
- Нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн санхүүжилт 2027 онд 344.2 тэрбум төгрөгт хүрэхээр тооцогдож, 2026 оны 115.4 тэрбум төгрөгтэй харьцуулахад эрс нэмэгдэж байна;
- Орон нутагт нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг орон нутгийн төсвийн зарлагын 0.5-аас доошгүй хувиас санхүүжүүлэх зохицуулалт нь орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээний чадавхийг бэхжүүлнэ.

Гурав. Зардал хялбарчлах боломжийн дүгнэлт

Хуулийн төслийн хэрэгжилтийн зардлыг бууруулах дараах боломжууд байна:

- Тохиолдлын тоог бууруулах: Эрүүл мэндийн байгууллагын тоог хамгийн өндрөөр авсан тул тухайн тохиолдлын тоог бууруулах боломжтой;
- Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах: Засгийн газрын гишүүн, захиргааны байгууллага болон орон нутгийн удирдах байгууллагын төлөвлөгөөг боловсруулах, батлахтай холбоотой үйл ажиллагааг 4 жилд 1 удаа хэрэгжүүлэх боломжтой;
- Хугацааг оновчтой тогтоох: Тухайн Эрүүл мэндийн тухай хууль нь суурь хууль тул тус үйл ажиллагааг хамгийн их хугацаанд гүйцэтгэхээр тогтоосон ба үүнийг илүү хурдан шуурхай явуулж зарцуулах хугацааг бууруулах боломжтой;
- Цахим хэлбэрт шилжүүлэх: Тайлан боловсруулах, хэлэлцүүлэг хийх зэрэг үйл ажиллагааг цахимаар хэрэгжүүлснээр зарцуулах хугацааг мэдэгдэхүйц бууруулах боломжтой.

Дөрөв. Санал

- 1) Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлахдаа ДНБ-д эзлэх эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн хувийг тогтоосон 29 дүгээр зүйлийн заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор улсын дунд хугацааны төсвийн хүрээнд тусгай нөөцийг тусгасан байх нь зүйтэй.
- 2) Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх, зарлагын үр ашгийг сайжруулах зорилгоор даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлэх, шимтгэлийн суурийг өргөтгөх талаар нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.
- 3) Орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох зорилгоор орон нутгийн төсвийн зарлагад эзлэх эрүүл мэндийн санхүүжилтийн хувийн хэмжээг тогтоосон заалтын хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй.
- 4) Анхан шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шатлалын зохистой хуваарилалтыг хангаж, дээд шатлалын эмнэлгийн ачааллыг бууруулах чухал нөхцөл болно.
- 5) Эрүүл мэндийн байгууллагуудад нэмэгдэж буй хүний нөөцийн болон материаллаг зардлыг санхүүжүүлэхийн тулд улсын төсөвт шаардагдах нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлж, урьдчилан тусгасан байх нь хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг хангах чухал нөхцөл юм.
- 6) Дижитал эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт нь урт хугацаандаа эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг бууруулах, чанарыг сайжруулах ач холбогдолтой бөгөөд эдгээр хөрөнгө оруулалтын хэрэгцээг тооцоолсны үндсэн дээр дунд хугацааны төсвийн хүрээнд тусгах нь зүйтэй.

Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын эрүүл мэндийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох, хүн амд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн стратегийн ач холбогдол бүхий баримт бичиг болно. Иймд тус хуулийн төслийг батлах, хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг зохих ёсоор тусгаж, хуулийн заалтуудын хэрэгжилтийг тасралтгүй хянаж, үнэлэн дүгнэж байх нь чухал ач холбогдолтой юм.